



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2023 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/В43

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төв эмнэлгийн нэгдсэн эмнэлгийн тусгай зөвшөөрлийн хугацааг 2028 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл 5 жилийн хугацаагаар сунгасан тул тус эмнэлгийн магадлан итгэмжлэлийг өмнөх батламжийн дугаар болон хүчинтэй хугацаагаар сэргээсүгэй.

3. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн арван тавдугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (С.Эрдэнэтуяа)-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (С.Сүнчин)-т даалгасугай.

САЙД

С.ЧИНЗОРИГ



141224467

Эрүүл мэндийн сайдын 2023 оны  
09 сарын 25 - ны өдрийн  
А/343 дугаар тушаалын хавсралт



**МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
БАЙГУУЛЛАГЫН НЭРС**

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Улаанбаатар, "Аюурвед-Энх" ХХК-ийн "Су Джок" эмнэлэг	248/2023	2 жил	2023.09.26	2025.09.26
2.	Улаанбаатар, "Энхсаран" ХХК-ийн сэргээн засах төв	249/2023	2 жил	2023.09.25	2025.09.25
3.	Говь-Алтай аймаг, Халиун сумын эрүүл мэндийн төв	250/2023	3 жил	2023.10.01	2026.10.01
4.	Говь-Алтай аймаг, Төгрөг сумын эрүүл мэндийн төв	251/2023	2 жил	2023.10.01	2025.10.01
5.	Завхан аймаг, Отгон сумын эрүүл мэндийн төв	252/2023	3 жил	2023.10.15	2026.10.15
6.	Өвөрхангай аймаг, "Чинмэнд" эмнэлэг	253/2023	3 жил	2023.10.01	2026.10.01
7.	Сүхбаатар аймаг, Мөнххаан сумын эрүүл мэндийн төв	254/2023	2 жил	2023.10.19	2025.10.19
8.	Сэлэнгэ аймаг, Хушаат сумын эрүүл мэндийн төв	255/2023	2 жил	2023.10.29	2025.10.29
9.	Төв аймаг, Баянжаргалан сумын эрүүл мэндийн төв	256/2023	2 жил	2023.10.02	2025.10.02
10.	Төв аймаг, Улаанбаатар төмөр замын ахмадын Булагтай сувилал	257/2023	2 жил	2023.10.26	2025.10.26
11.	Увс аймаг, Аймгийн нэгдсэн эмнэлэг	258/2023	3 жил	2023.12.01	2026.12.01
12.	Ховд аймаг, 0130 дугаар цэргийн ангийн эрүүл мэндийн төв	259/2023	1 жил	2023.09.25	2024.09.25